



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/112

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 14/01 тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Беларусь улсад зохион байгуулагдах боксын нээлттэй тэмцээнд Булган аймгийн баг тамирчдыг оролцуулсугай.

2. Баг тамирчдын нээлттэй тэмцээнд оролцох зардалд шаардагдах 20,700,000 (хорин сая долоон зуун мянга) төгрөгийг Биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ